




Уул уурхайн салбараас 2020 онд төсвийн нийт орлогын 25 хувийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.


ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГОД УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ОРЛОГЫН ЭЗЛЭХ ХУВЬ (2014-2020 ОН)




2020 онд уул уурхайн салбараас бүрдүүлэх төсвийн орлого өмнөх оныхоос 2 хувиар буурч 25 хувь болно.

УУЛ УУРХАЙН ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ҮНЭ, ХЭМЖЭЭ

Зэс, алтны үнэ (2014-2020 он)



Экспортлох хэмжээ



УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ОРЛОГЫН БҮТЭЦ, 2020 ОНД (ТЭРБУМ ТӨГРӨГ)

Үзүүлэлт	Зэс	Нүүрс	Алт	Цайр	Төмөр	Бусад	Нийт
АМНАТ	493	594	126	29	27	24	1293
ААНОАТ	223	670	22	40	7	39	1001
Ногдол ашиг	150	23				5	178
Гаалийн татвар хураамж	104	102		2	23	77	308
Бусад	190	105	18	5	14	83	415
Нийт	1160	1494	166	76	71	228	3195

2020 оны уул уурхайн салбарын ААНОАТ-ын орлогын хэмжээг 2019 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 608 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 1.85 их наяд төгрөгөөр тооцсон нь өөдрөг тооцоолол гэж үзэж байна.



Засгийн Газар 2020 оны эдийн засгийн өсөлтийг өөдрөгөөр харж, төсвийн орлогыг өндөр тооцжээ.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оноос 22 хувиар өсөж, 11.8 их наяд төгрөг болно.

НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО (2016-2020 он)



2020 ОНЫ ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГЫН БҮТЭЦ (ӨСӨЛТ 2019 ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД)

ТАТВАРЫН ОРЛОГО 10.66 ИХ НАЯД ₮ (ӨСӨЛТ: 24%)

- Орлогын албан татвар **2.76 их наяд ₮** (37.1%▲)
- Хөрөнгийн албан татвар **0.16 их наяд ₮** (19.3%▲)
- Тусгай зориулалтын орлого **0.02 их наяд ₮** (30.3%▲)
- Нийгмийн даатгалын орлого **2.40 их наяд ₮** (41.6%▲)
- Онцгой албан татвар **0.95 их наяд ₮** (13.8%▲)
- Бусад татвар (Төлбөр, хураамж) **0.85 их наяд ₮** (4.1%▲)
- НӨАТ **2.63 их наяд ₮** (13.1%▲)
- Гаалийн албан татвар **0.87 их наяд ₮** (17.7%▲)

ТАТВАРЫН БУС ОРЛОГО 1.14 ИХ НАЯД ₮ (ӨСӨЛТ: 4.7%)


МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг ОУВС өмнөх оноос 1.1 хувиар, Сангийн Яам 2 хувиар буурахаар таамаглажээ.

ДНБ-ИЙН ӨСӨЛТ



ДНБ, ИХ НАЯД ТӨГ (нэрлэсэн үнээр)



Дотоод болон гадаад хүчин зүйлээс хамаарч ДНБ-ий өсөлт 6 хувьд хүрэхгүй байх эрсдэлтэй. Төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй бол засгийн газрын өр нэмэгдэх, төсвийн хөрөнгө оруулалтууд зогсох зэрэг олон эрсдэл учирна.

¹ "гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого" гэж тухайн жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа тухайн төрлийн эрдэс баялгаас энэ хуулийн 11.1.3-т заасны дагуу тодорхойлсон үнийн түвшнийг баримтлан тооцож төсөвт оруулах орлогын дүн (Төсвийн тогтвортой байдлын тухай хууль)



МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ ТӨСВИЙН ОРЛОГОД УЧИРЧ БОЛОХ ГАДААД ЭРСДЭЛ


ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

Олон улсад тодорхойгүй нөхцөл байдал давамгайлж байгаа учраас олон улсын байгууллагууд эдийн засгийн өсөлтийн таамаглалаа бууруулж байна.

- Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын судалгаагаар 2018 онд дэлхийн эдийн засаг 3.6 хувь өссөн ба 2019 онд 4 хувь өснө гэж таамагласан. Харин 2019 оны 9 сард хийсэн тооцооллоор 2.9 хувь болтол бууруулжээ.
- БНХАУ-ын хувьд 2019 онд өсөлт 6.1 хувь, харин 2020 онд 5.7 хувь болж буурахаар байна.

Түүхий эдийн зах зээл дээрх, ялангуяа БНХАУ-ын нүүрсний импортын эрэлт буурах эрсдэлтэй.

БНХАУ-ЫН НҮҮРСНИЙ ИМПОРТЫН ЗАХ ЗЭЭЛД ГОЛ НИЙЛҮҮЛЭГЧ ОРНУУДЫН ЭЗЛЭХ ХЭМЖЭЭ (ХУВИАР, 2018 ОНЫ БАЙДЛААР)



Монгол Улсын нүүрсний экспортын хэмжээ БНХАУ-ын импортын зах зээлийн 19.2 хувийг эзэлж байна. 2019 оны эхний 9 сарын байдлаар БНХАУ-ын нүүрсний импортын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 9.5 хувиар нэмэгдсэн байна. Сингапурт байрлалтай нүүрсний брокеруудын таамаглалаар БНХАУ-ын 2020 оны импорт 305 сая тонн байхаар байна.

Шанси болон Өвөр Монголын Өөртөө Засах Автономит улсад түс бүрдээ 5 сая тонн олборлох хүчин чадал бүхий нүүрсний уурхайн төсөл эхэлсэн учир БНХАУ-ын дулааны нүүрсний импортын эрэлт буурах магадлалтай.

БНХАУ-ын зах зээл дээрх нүүрсний өрсөлдөөн нэмэгдэж байна. Хэдийгээр гадаад зах зээлд өсөлт байгаа гэхэд дотоодоос шалтгаалах (тээвэрлэлт, гаалийн үйл ажиллагаа, олборлолт) хүчин зүйлээс хамаарч, Монгол Улсын экспортын хэмжээ 42 сая тонн хүрэхгүй байх эрсдэлтэй.






МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ ТӨСВИЙН ОРЛОГО БҮРДЭЛТЭД УЧИРЧ БОЛОХ ДОТООД ЭРСДЭЛ

ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД ААНОАТ-ЫН ОРЛОГО 49 ХУВИАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО 41.6 ХУВИАР ӨСӨХӨӨР ТӨЛӨВЛӨГДСӨН НЬ БИЕЛЭХГҮЙ БАЙХ ЭРСДЭЛТЭЙ.

ОРЛОГЫН ӨСӨЛТ (2019 онтой харьцуулахад)




ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (тэрбум төг)



2020 ОНД ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТЭД УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛ

АЖ АХУЙ НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ОРЛОГЫН ХҮРЭЭНД:



Шинэчлэн батлагдсан “Татварын ерөнхий хууль” 2020 оны 1 сарын 1-ээс эхлэн хэрэгжихтэй холбоотой гол өөрчлөлтөөс:

- 1%-ийн албан татварыг нийт татвар төлөгчдийн 96.6% нь төлөх тул татварын орлогын хэмжээ багасна.
- 25%-ийн албан татвар төлөх ААН-ийн босгыг 3 тэрбум төгрөгөөс 6 тэрбум төгрөг болгож нэмэгдүүлсэн. Улмаар ААНОАТ-ын орлогын хэмжээ буурна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГЫН ХҮРЭЭНД:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ (2017-2020 ОН)

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Тэтгэвэр	14	16	17	19
Тэтгэмж	1.8	1.8	1.8	1.8
Ажилгүйдэл	0.4	0.4	0.4	0.4
Эрүүл мэнд	4	4	4	4
ҮОМШӨ	0.8-2.8	0.8-2.8	0.8-2.8	0.8-2.8

2020 оны төсвийн орлогын хувьд хамгийн эрсдэлтэй нь НДШ-ийн орлого юм. Шимтгэлийн хэмжээ нэмэгдэхэд хамрагдалт нь буурах, даатгуулагч цалин хөлсөө дахин тохиролцох, улмаар төлөх дүн багасах зэрэг эрсдэлтэй. Тиймээс 2020 онд нийгмийн даатгалын орлогыг 705 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 2.4 их наяд төгрөгөөр тооцсон нь хэт өөдрөг тооцоолол гэж үзэж байна.

